



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

᠒᠐᠒᠒ оны ᠐᠗ сарын 15 өдөр

Дугаар 1/78

Алтай хот

┌ **Тусгай зөвшөөрөлд өөрчлөлт** ┐
оруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9, 8.13 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6 дахь заалт, Засгийн газрын 2019 оны “Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 183 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 24 дүгээр дүгнэлтээр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэд шинээр 1 салбар бүлгийг ажиллуулах болсонтой холбогдуулан Есөнбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулсугай.

2.Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд зохих бичилт хийж, баталгаажуулахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Л.Отгончимэг), үйл ажиллагаанд нь хяналт тавьж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Д.Алтанзагас)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР